



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 03
№13 (1261)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

206.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 12	1087
------	-------------------------------	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

207.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 17	1088
------	--	-----------	------

208.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 18	1088
------	--	-----------	------

209.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 19	1089
------	--	-----------	------

210.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 20	1089
------	--	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

211.	Журам батлах тухай	Дугаар 405	1090
------	--------------------	------------	------

212.	Журам батлах тухай	Дугаар 406	1096
------	--------------------	------------	------

᠕᠑᠕.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠑
᠕᠑᠑.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠᠶᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠠᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠳᠠᠭ᠎ᠠ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠐
᠕᠑᠐.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠙
᠕᠐᠙.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠙
᠕᠐᠘.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠘
᠕᠐᠗.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠘
᠕᠐᠖.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠᠶᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠠᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠳᠠᠭ᠎ᠠ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠗
᠕᠐᠑.	ᠮᠠᠨᠠ ᠰᠤᠭᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ	ᠮᠠᠨᠠᠶᠢᠨᠭ᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠲᠠᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠳᠠᠳᠠᠭ᠎ᠠ	ᠭᠠᠨᠨᠠᠭᠠᠨ	᠑᠐᠕᠗



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон хамт баталсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсугай.

2.Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Fox - on UKH Mongol on Dowlgk

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ
ᠲᠤᠮᠤᠨ ᠲᠤᠭᠠᠷ 12

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ
ᠲᠤᠮᠤᠨ ᠲᠤᠭᠠᠷ 12

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ
ᠲᠤᠮᠤᠨ ᠲᠤᠭᠠᠷ 12

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ
ᠲᠤᠮᠤᠨ ᠲᠤᠭᠠᠷ 12

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠤᠯ
ᠲᠤᠮᠤᠨ ᠲᠤᠭᠠᠷ 12



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цолмонгийн Амарыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Баяраагийн Булгантамирыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бэхбатын Наранжаргалыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 47 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Рагчаабазарын Баярхүүг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 405

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй бүтээлийг ашигласны төлбөрийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид нөхөн олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2022 оны 405 дугаар
тогтоолын хавсралт

**ЗОХИОГЧ, ЗОХИОГЧИЙН ЭРХ ЭЗЭМШИГЧ НЬ ТОДОРХОЙГҮЙ
БҮТЭЭЛИЙГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ЗОХИОГЧ, ЗОХИОГЧИЙН
ЭРХ ЭЗЭМШИГЧИД НӨХӨН ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.3 дахь хэсэгт заасан зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй бүтээл (цаашид “бүтээл” гэх)-ийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “оюуны өмчийн байгууллага” гэх) бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлж, түүнийг ашиглах зөвшөөрөл олгох, зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч тодорхой болсны дараа бүтээлийг төлбөртэй ашиглуулсны



төлбөрийн зохих хувийг нөхөж олгохтой холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Холбогдох хуулиар тусгайлан зохицуулсан бол зохиогчийн эрхийн бүтээл ашиглах онцгой эрхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон хандив, дэмжлэг, тусламжаар бэлэглэсэн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид энэ журам хамаарахгүй.

Хоёр.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй бүтээлийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх

2.1.Бүтээлийг оюуны өмчийн байгууллага нь хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдийн санаачилгаар Оюуны өмчийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасан мэдээллийн санд бүртгэнэ.

2.2.Бүтээлийг мэдээллийн санд бүртгэх, сан бүрдүүлэх үйл ажиллагааг оюуны өмчийн байгууллагын зохиогчийн эрхийн асуудал хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

2.3.Бүтээлийн бүртгэл, мэдээллийн сан нь эвдэрч гэмтсэн, устсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах эх баримт, цаасан мэдээллийг давхар бүрдүүлнэ.

2.4.Бүтээлийг бүртгүүлэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

2.4.1.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй талаар нотлох үндэслэл бүхий хүсэлт;

2.4.2.судалгаа, шинжилгээний ажлын тайлан;

2.4.3.дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт;

2.4.4.гэрэл зураг, түүнийг агуулсан хальс;

2.4.5.дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг;

2.4.6.өв залгамжлагчийн талаарх мэдээлэл;

2.4.7.зураг төсөл;

2.4.8.бүртгэлд холбогдох бусад лавлагаа.

2.5.Бүтээлийг иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн мэдээллийн санд байршуулан нийтэд мэдээлнэ.

2.6.Бүтээлийн мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувилахыг хориглоно.

**Гурав.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь
тодорхойгүй бүтээлийг ашиглах
зөвшөөрөл олгох**

3.1.Иргэн, хуулийн этгээд энэ журмын 2.1-д заасан мэдээллийн сан дахь бүтээлийг ашиглах зориулалт, зорилго, хамрах хүрээг тодорхойлсон хүсэлтийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр оюуны өмчийн байгууллагад гаргана.

3.2.Оюуны өмчийн байгууллага нь энэ журмын 2.1-д заасан мэдээллийн санд байршуулснаас хойш хуанлийн 90 хүртэлх хоногийн хугацаанд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тогтоогдоогүй бол энэ журмын 3.1-д заасан хүсэлт гаргагчид ажлын 10 хоногт багтаан Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.2-т зааснаар тухайн бүтээлийг ашиглах зөвшөөрөл олгоно.

3.3.Энэ журмын 3.2-т заасан зөвшөөрлийг үндэслэн зохиогчийн эрхийн асуудал хариуцсан нэгжийн дарга оюуны өмчийн байгууллагыг төлөөлөн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.1.2-т заасан бүтээл ашиглах лицензийн гэрээг байгуулна.

3.4.Энэ журмын 3.3-т заасан гэрээний хугацаа 2 жил хүртэл байх бөгөөд гэрээний хугацааг энэ журмын 3.1-д заасан хүсэлт гаргагчийн хүсэлтэд заасан хугацааг харгалзан сунгаж болно.

3.5.Энэ журмын 3.4-т заасан хугацаанд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч тодорхой болсон тохиолдолд зөвшөөрлийг цуцалж, гэрээг дуусгавар болгоно.

3.6.Энэ зүйлийн 3.5-д заасан гэрээг дуусгавар болгох тохиолдолд иргэн, хуулийн этгээд тухайн бүтээлийн зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болохыг нотлохдоо эх бүтээл, гар бичмэл, нийтэлсэн хэвлэл, төрөл садангийн лавлагаа, өвлөх эрхийн гэрчилгээ, гэрээслэл, гэрэл зураг, дуу авиа бүхий дүрст бичлэг бусад холбогдох нотлох баримт бичгийг оюуны өмчийн байгууллагад ирүүлнэ.

3.7.Энэ журмын 3.3-т заасан гэрээ байгуулсан бүтээлийг ашигласнаас хойш 10 жилийн хугацаанд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй, мөн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 15.6-д заасан тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрхийг оюуны өмчийн байгууллага эдэлнэ.

3.8.Энэ журмын 3.2-т заасан хугацаанд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тогтоогдвол Зохиогчийн эрхийн тухай хуулийг дагаж мөрдөнө.

Дөрөв.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхой болсны дараа бүтээлийг төлбөртэй ашиглуулсны төлбөрийн зохих хувийг нөхөж олгох

4.1.Бүтээл ашиглуулсны төлбөрийг бүтээлийн төрөл, шинж байдал, чанар, үнэ цэн, зах зээлийн эрэлт хэрэгцээг үндэслэн Оюуны өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан үнэлгээчин тогтоох бөгөөд үнэлгээ хийхтэй холбогдох зардлыг хүсэлт гаргагч талууд хариуцна.

4.2.Төлбөртэйгээр ашиглуулсан бүтээлийн төлбөрөөс нөхөн төлбөр авах зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь дор дурдсан баримт бичгийг цаасаар, эсхүл цахим хэлбэрээр оюуны өмчийн байгууллагад хүргүүлнэ:

4.2.1.хүсэлт;

4.2.2.хүсэлт гаргагч иргэн бол иргэний холбогдох баримт бичгийн хуулбар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.2.3.энэ журмын 3.6-д заасан холбогдох баримт бичиг.

4.3.Оюуны өмчийн байгууллага нөхөн төлбөр авахаар ирүүлсэн

энэ журмын 4.2-т заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан эсэхийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан 30 хүртэлх хоногийн хугацаанд хянан шалгаж, зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болохыг тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

4.4. Энэ журмын 4.2-т заасан зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчээс нөхөн төлбөр авахаар ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 51.1-д заасан Зөвлөл хэлэлцэн, төлбөр буцаан олгох хэмжээг тогтооно.

4.5. Энэ журмын 4.4-т заасан Зөвлөл нь нөхөн төлбөрийн хувь хэмжээг тогтоохдоо энэ журмын 3.3-т заасан гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн гэрээнд заасан төлбөрийн хэмжээнээс холбогдон гарсан зардлыг хасаж тооцох ба Зохиогчийн эрхийн тухай хуулийн 37.5, 37.6-д заасныг баримтална.

4.6. Оюуны өмчийн байгууллага нь энэ журмын 4.2.2, 4.2.3-т заасан баримт бичгийг хянан шалгахдаа холбогдох төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс лавлагаа, тодорхойлолт, шийдвэрийг гаргуулан авах, ярилцлага хийх болон хүсэлт гаргагч талуудын нотлох баримт гаргах хүсэлтэд заасан холбогдох бусад ажиллагааг хийнэ.

4.7. Оюуны өмчийн байгууллага энэ журмын 4.4-т заасан Зөвлөлөөс тогтоосон хэмжээг үндэслэн төлбөр нөхөн олгох шийдвэрийг гаргана.

4.8. Оюуны өмчийн байгууллага энэ журмын 4.3-т заасан хугацаанд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болох нь нотлогдоогүй бол нөхөн төлбөр олгохоос татгалзан, энэ журмын 4.2-т заасан баримт бичгийг хүсэлт гаргагчид 7 хоногт буцаан хүргүүлнэ.

4.9. Нөхөн төлбөрийг энэ журмын 5.3-т заасан данснаас зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн арилжааны банканд дахь харилцах дансанд, оюуны өмчийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний хөлсийг оюуны өмчийн байгууллагын зохих дансанд тус тус шилжүүлнэ.

Тав.Бусад

5.1.Иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.4-т заасан Зөвлөлийн төлбөр буцаан олгох хэмжээг эс зөвшөөрвөл гомдлоо оюуны өмчийн байгууллагад гаргана.

5.2.Нөхөн төлбөр олгох үйл ажиллагаатай холбоотой маргаан үүссэн тохиолдолд маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн хүсэлт гаргагчтай холбоотой нөхөн төлбөр олгох ажлыг түдгэлзүүлнэ.

5.3.Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч тодорхойгүй бүтээлийг төлбөртэйгээр ашиглуулснаас олох орлогыг оюуны өмчийн байгууллагын дансанд байршуулна.

5.4.Бүтээлийг ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд төлбөрийг энэ журмын 5.3-т заасан дансанд байршуулна.

5.5.Оюуны өмчийн байгууллага энэ журмын 3.7-д заасан хугацаа дууссаны дараа мөн журмын 5.3-т заасан дансанд байршуулсан төлбөрийг улсын орлого болгоно.

5.6.Энэ журмын 5.5-д заасан тохиолдолд зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь төлбөртэйгээр ашиглуулсан бүтээлийн төлбөрөөс нөхөн олгохгүй.

5.7.Улсын захиалгаар, төсвийн хөрөнгөөр бий болсон бүтээл ашиглах онцгой эрхийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад этгээд хэрэгжүүлэхийг хориглоно.

5.8.Иргэн, хуулийн этгээд энэ журмын 5.1-д заасан оюуны өмчийн байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

---oO---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 406

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.6, 22.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээдийн тэсрэх материалын үйлдвэр, агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зориулалтын тоног төхөөрөмж, мэргэжлийн ажиллах хүчинд тооллого явуулж, шинэчилсэн бүртгэл хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ж.ГАНБААТАР

Засгийн газрын 2022 оны 406 дугаар
тогтоолын хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээд болон хяналт тавих чиг үүрэг

бүхий төрийн байгууллагаас мэдээллийн нэгдсэн санд ирүүлэх мэдээллийн агуулга, давтамж, мэдээллийг баталгаажуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн санг хөтлөхдөө Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

1.3.Мэдээллийн нэгдсэн сан нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хязгаарлалттай мэдээллийн ангилалд хамаарна.

Хоёр.Мэдээллийн нэгдсэн санг хөтлөх

2.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “мэдээлэл хариуцагч” гэх) мэдээллийн нэгдсэн санг хөтлөх бөгөөд уг сан дор дурдсан дэд сангаас бүрдэнэ:

2.1.1.Тэсэлгээний ажил явуулах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн мэдээлэл болон бусад холбогдох бичиг баримтуудыг бүртгэх “Хуулийн этгээдийн дэд сан”;

2.1.2.Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан (туршсан) тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн тайлан, мэдээг аж ахуйн нэгжүүдээс цахим систем ашиглан хүлээн авч нэгтгэх, статистик мэдээ гаргах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах, улсын хилээр нэвтрүүлж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эд, пиротехникийн хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн бүртгэлийг бүртгэх “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн дэд сан”;

2.1.3.Тэсэлгээчин болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах эрхийн үнэмлэхтэй ажиллагчдын шилжилт, хөдөлгөөн, амь насны даатгал, шинжээчдийн бүртгэл болон бусад холбогдох мэдээллийг бүртгэх “Мэргэжлийн боловсон хүчний дэд сан”;

2.1.4.Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, хадгалах байр, агуулах, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, лабораторийн мэдээллийг бүртгэх “Тэсрэх материалын үйлдвэр, агуулах, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн дэд сан”.

2.2.Мэдээлэл хариуцагчид тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээд болон хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас энэ журмын 2.1-д заасан мэдээллийг ирүүлснээс хойш ажлын тав хоногийн дотор мэдээллийг баталгаажуулан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.3.Энэ журмын 2.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан талаар холбогдох этгээдээс мэдээлэл хариуцагчид мэдэгдсэн тохиолдолд тухайн өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд даруй оруулна.

Гурав.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх

3.1.Гаалийн байгууллага нь дараахь мэдээллийг дор дурдсан хугацаанд мэдээлэл хариуцагчид хүргүүлнэ:

3.1.1.улсын хилээр нэвтрүүлж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эдийг тухай бүр;

3.1.2.улсын хилээр нэвтрүүлж байгаа пиротехникийн хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийг тухай бүр;

3.1.3.улсын хилээр нэвтрүүлсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээ, тайланг сар тутам.

3.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч хуулийн этгээд нь дараахь мэдээллийг дор дурдсан хугацаанд мэдээлэл хариуцагчид цахимаар хүргүүлнэ:

3.2.1.хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан (туршсан) тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг тусгасан мэдээллийг хагас жил тутамд;

3.2.2.холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх авсан сургалтын байгууллага тэсэлгээчин, пиротехникийн хэрэгслийн мэргэжлийн боловсон

хүчин бэлтгэсэн талаарх мэдээллийг тухай бүр;

3.2.3.хуулийн этгээд нь чанарын шаардлага хангахгүй болсон, ашиглах хугацаа нь дууссан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгасан тухай тайланг тухай бүр;

3.2.4.хуулийн этгээдийн үндсэн мэдээлэлд өөрчлөлт орсон бол энэ тухайгаа ажлын 5 хоногт.

3.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахын газрын байнгын байршлыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу тогтоож мэдээллийн нэгдсэн санд ажлын таван өдрийн дотор бүртгүүлэхээр мэдээлэл хариуцагчид хүргүүлнэ.

Дөрөв.Бусад

4.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 22.2-т заасны дагуу мэдээллийн нэгдсэн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцаас санхүүжүүлнэ.

4.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сантай холбогдолтой мэдээллийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 22.4-т заасан байгууллага авч ашиглах бөгөөд санд байгаа мэдээллийг хүн, хуулийн этгээд ашиглахтай холбогдсон харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулна.

4.3.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oO---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 200003